



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 10 сарын 10 өдөр

Дугаар А/319

Улаанбаатар хот

Бүх нийтийн их цэвэрлэгээ зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 31 дүгэээр зүйлийн 31.1.7 дахь заалт, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.5 дахь заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2009 оны 63 дугаар тогтоол, 2012 оны 61 дүгээр тогтоол, Улаанбаатар хотын ерөнхий менежерийн 2017 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн А/04 тоот тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэдийн ая тухтай ажиллаж, амьдрах таатай орчин, нөхцлийг бүрдүүлэхэд дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, айл өрх, төрийн болон төрийн бус байгууллагууд, томоохон зах, худалдааны төвүүд, сууц өмчлөгчдийн холбоод, хэрэглэгчдэд үйлчлэх төвүүд, цэргийн анги нэгтгэлүүд, их дээд сургууль болон ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүд орчныхоо 50 м газрын цэвэрлэгээ хийх ажлыг 2017 оны 10 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулсугай.

2. Бүх нийтийн их цэвэрлэгээ зохион байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр, цэвэрлэгээ зохион байгуулах хороо, хамтран ажиллах хэлтэс, албадын хуваарийг хоёрдугаар, цэвэрлэгээ зохион байгуулах ажлын удирдамжийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Их цэвэрлэгээний ажлыг зохион байгуулах, хуримтлагдсан хог хаягдлыг шуурхай тээвэрлүүлэхийг Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс /Б.Отгонхүү/, Нийтлэг үйлчилгээний газар-1, 2, 3, 4 орон нутгийн өмчит аж ахуйн тооцот үйлдвэрийн газар /Ж.Мөнх-Од, Д.Нэргүй, Х.Өлзийхорол, Э.Хатанбаатар/-т, бүх нийтийн цэвэрлэгээг хорооны нутаг дэвсгэрт зохион байгуулж аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг өргөнөөр хамруулж ажиллахыг хороодын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4. Цэвэрлэгээ хангалтгүй хийсэн газруудад хяналт тавьж, холбогдох хуулийн дагуу захиргааны арга хэмжээ авч ажиллахыг Мэргэжлийн хяналтын хэлтэс /Д.Цэнд-Очир/, Төрийн Захиргаа удирдлагын хэлтэс /А.Пүрэвдулам/-т, цэвэрлэгээний ажлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлахыг Хэвлэл мэдээллийн алба /Д.Цэнгэлмаа/-д тус тус даалгасугай.

5. Цэвэрлэгээний ажилд аж ахуйн нэгж, байгууллагуудыг өргөнөөр оролцуулах, хяналт тавих, мэдээг нэгтгэж дутагдалтай ажилласан хороо, байгууллага, аж ахуйн нэгжид авах арга хэмжээний санал боловсруулж танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Т.Батцогт/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Т.БАЯСАХ